

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтын хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 284 дүгээр тогтоолоор Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэлийн авто замын хэсэг болох Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замыг 4 эгнээ бүхий хатуу хучилттай авто зам болгон өргөтгөн, шинэчлэх шийдвэрийг гаргасан.

Монгол Улсын Засгийн газар болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк /цаашид ЕСБХБ гэх/ хооронд 2019 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр байгуулсан “Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр” Монгол Улсын Их Хурлаар 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр соёрхон батлагдсан бөгөөд тус хэлэлцээрийг үндэслэн “Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам төсөл”-ийг хэрэгжүүлэх зорилгоор тусгайлсан зээлийн гэрээг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Монгол Улсын Засгийн газар болон ЕСБХБ хооронд байгуулсан.

Тус Зээлийн гэрээний Хавсралт 1-д төслийн хамрах хүрээг тодорхойлсон ба дараах ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхээр тусгагдсан болно. Үүнд:

Хэсэг А- Хөрөнгийн зарцуулалт ба Хяналт (137 сая ам.долларын зээлийн хөрөнгөөр хэрэгжих)
Зам барилгын ажил /Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам/
Хяналтын инженер

Хэсэг Б – Техникийн хамтын ажиллагаа (буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжих)

Төслийн зохицуулагч

Төслийн хэрэгжилтэд үзүүлэх дэмжлэг

Байгууллагын үйл ажиллагаанд үзүүлэх дэмжлэг

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний зөрүү, дутууг тодорхойлох шинжилгээ болон нээлттэй байдлыг хангах

Байгаль орчин болон нийгмийн хамгааллын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэхэд үзүүлэх дэмжлэг зэрэг ажил, үйлчилгээ болно.

Энэхүү 2 эгнээ авто замыг шинэчлэн засварлах ажлын техник-эдийн засгийн үзүүлэлт (ТЭЗҮ)-ийг Монголын Барилга байгууламжийн Төслийн Зөвлөхүүдийн Групп ХХК (МББТЗГ буюу МСРСgr) 2017 онд гүйцэтгэж, зураг төслийг боловсруулав.


Төслийн байршил

Нийт **202,4** км-ийн урттай авто зам барих төсөл нь Улаанбаатар хотын гадна орших Дархан-Эмээлтийн тойрог уулзвараас эхлэх бөгөөд нийт гурван аймаг, зургаан сум, буюу Төв аймгийн Баянчандмань ба Борнуур сум, Сэлэнгэ аймгийн Мандал ба Баянгол сум, Дархан-Уул аймгийн Хонгор сумдын нутгийг дайран өнгөрч, мөн Дархан-Уул аймагт орших Дархан хотын өмнөд хэсэгт төгсөнө. Төсөл нь дараах таван хэсэг буюу “багц”-д хуваагдана.

Хүснэгт 1. Төслийн замын хэсэг, чиглэл

Хэсэг	Тайлбар	Урт (м)	Төслийн замын урт-эхлэх м	Төслийн замын урт- төгсөх м	Км тэмдэг Эхлэх	Км тэмдэг Төгсөх
I	Дархан-Эмээлтийн тойрог уулзвараас эхлээд Хар Модотын даваа (52-н даваа)-ны ар хүртэл	37,281.77	0	37,281.77	18.9	56.18
II	Хар Модотын давааны араас Тайсын хөтөлийн өвөр хүртэл	45,500.17	37,281.77	82,781.94	56.18	101.68
III	Урьхан зоогийн газрын орчмоос Бор толгой буюу Төв аймгийн Сүмбэр сум чиглэлийн замын уулзвар хүртэл	45,753.06	82,781.94	128,535.00	101.68	147.44

IV	Бор толгой буюу Төв аймгийн Сүмбэр сум чиглэлийн замын уулзвараас Цайдамын хөндий хүртэл	45,050.56	128,535.00	173,585.56	147.44	192.49
V	Цайдамын хөндийгөөс Дархан хотын тойрог уулзвар хүртэл	28,840.00	173,585.56	202,425.56	192.49	221.33



Зураг Error! No text of specified style in document.. Төслийн байршил

А. Худалдан авах ажиллагаа

- 1. Барилга угсралтын ажлын гүйцэтгэгч.** Улаанбаатар-Дархан чиглэлийн шинээр баригдах авто замын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2019 оны 9 дүгээр сарын 06-ны өдөр зарлаж, тус тендерийг 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр нээсэн. Сонгон шалгаруулах үйл ажиллагааг Олон улсын зөвлөхийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж, холбогдох дүрэм журманд нийцүүлэн үнэлж дуусаад, Банкинд хүргүүлээд байна. 2020 оны 6 дугаар сард багтаан гэрээ байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.
- 2. Техник технологийн хяналт тавих зөвлөхийн үйлчилгээ.** Тус тендерийг 2019.10.29-ний өдөр зарласан. Сонгон шалгаруулах үйл ажиллагааг Олон улсын зөвлөхийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж, холбогдох дүрэм журманд нийцүүлэн үнэлж дуусаад, Банкинд хүргүүлээд байна. 2020 оны 5 дугаар сард багтаан гэрээ байгуулахаар ажиллаж байна.
- 3. Төслийн хэрэгжилтэд үзүүлэх дэмжлэг зөвлөх үйлчилгээ.** Төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээний компанийг сонгон шалгаруулах тендерийг 2019.08.15 болон 2019.12.06-ны өдөр тус тус 2 удаа зарласан боловч тендер амжилтгүй буюу хүчингүй болсон байна. Иймд ажлын даалгаварт өөрчлөлт оруулж, дахин зарлахаар төлөвлөн ажиллаж байна.
- 4. Авто замын засвар арчлалтын хөрөнгө оруулалтыг сайжруулах, салбарын чадавхийг бэхжүүлэх зөвлөх үйлчилгээ.** Тус зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг хэлэлцэж, холбогдох саналыг Банкинд хүргүүлэв. Банкны зүгээс хүлээн авснаа нотолж, санхүүгийн мэргэжилтэнд шилжүүлснээ мэдэгдээд байна. Тендер удахгүй зарлагдана.